

ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛӨӨС МОНГОЛБАНКИНД ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ ТАНИЛЦАВ

Монголбанкны Хяналтын зөвлөлийн ээлжит хурал 2012 оны 3 дугаар сарын 27-ны өдөр болж Монголбанкны Эрдэнэсийн санг бүрдүүлэх, хадгалах, хамгаалах байдалтай танилцаж шалгасан Хяналтын зөвлөлийн гишүүн Ж.Үнэнбатын мэдээлэл, Хөндлөнгийн аудитын үйл ажиллагаа нягтлан бодох бүртгэлийн олон улсын зарчимд нийцэж буй эсэх, 2008-2010 онд аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар Монголбанкнаас хийсэн ажилтай танилцсан Хяналтын зөвлөлийн гишүүн Д.Нямаагийн мэдээлэл, Монголбанкны Ерөнхийлөгч хуулийн хүрээнд эрхээ хэрэгжүүлэх баталгааны хэрэгжилтийн байдалтай танилцсан Хяналтын зөвлөлийн гишүүн Д.Моломжамцын мэдээлэл, Монголбанкны программ хангамжийг боловсронгуй болгох, сүлжээний найдвартай ажиллагаа, мэдээллийн нууцлалыг хэрхэн ханган ажиллаж байгаа тухай Монголбанкны Мэдээллийн технологийн газрын захирлын сонголт болон Хяналтын зөвлөлөөс 2011 онд гаргасан шийдвэрийн биелэлтийн байдал зэрэг асуудлыг хурлаараа авч хэлэлцэн шийдвэр гаргасан байна.

1. Монголбанкны Эрдэнэсийн санг бүрдүүлэх, хадгалах, хамгаалах байдалтай танилцсан Хяналтын зөвлөлийн гишүүний мэдээлэл болон Монголбанкны холбогдох албадын захирлын тайлбарыг сонссон байна. Монголбанкны удирдлагын зүгээс Эрдэнэсийн сангийн тухай Монгол Улсын хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдлыг шалгаж холбогдох арга хэмжээ авах нь зүйтэй гэж үзжээ.

Эрдэнэсийн сангийн үйл ажиллагааны дансдын хөрөнгийн хөдөлгөөнийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийж байгаа эсэхэд ДАГ-аас тавих хяналт, тайлагнах үйл ажиллагааг сайжруулах, Эрдэнэсийн сангийн холбогдох сангийн хөрөнгийг электрон хэлбэрээр бүртгэн баримтжуулах ажлыг 2012 оны эхний хагаст багтаан чанартай хийж дуусгах, Монголбанкны Эрдэнэсийн санд мөнгөжөөгүй алтнаас бусад үнэт зүйлсийг хүлээж авах, зарлагын гүйлгээ хийх, үнэлгээ тогтоох асуудлыг хариуцсан мэргэжлийн комисс байгуулж үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах, Эрдэнэсийн сангийн үйл ажиллагааны нууцын зэрэглэлийг бууруулж олон нийтийн хараа хяналтад оруулах талаар болон Эрдэнэсийн сангийн тухай Монгол Улсын хуулийн хэрэгжилтийн байдлыг шалгаж, цаашид хуулийг боловсронгуй болгох санал боловсруулах талаар Монголбанкны Ерөнхийлөгчид зөвлөмж болгов.

2. Монголбанкны 2008, 2009, 2010 оны санхүүгийн тайланд Эрнст энд Янг Монголия ХХК хөндлөнгийн аудит хийж Дэлхийн нягтлан бодогчдын холбоо (IFAC)-ноос батлан гаргадаг Аудитын олон улсын стандартын дагуу аудит гүйцэтгэж, тайлан гаргаж ирүүлсэн байна.

Монголбанкны удирдлага 2008-2010 оны санхүүгийн тайланд Эрнст энд Янг Монголия компаниас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг сайн зохион байгуулж байгааг тэмдэглэж, Монголбанкны санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн программд өөрчлөлт оруулах болон программд нэвтрэх эрхийн зохицуулалттай холбоотой зөвлөмжийг жил бүр өгч ирснийг анхааралдаа авч Монголбанкинд ашиглагдаж буй мэдээллийн технологийн болон хяналтын тогтолцоог сайжруулах нь зүйтэй гэж үзэв.

Мөн Монголбанкны санхүүгийн тайланд аудит хийх байгууллагыг сонгохдоо Төв банкны тухай хууль тогтоомжид зааснаар Хяналтын зөвлөлийн саналыг урьдчилан авах тухай заалтыг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөсөн байна.

Монголбанкны санхүүгийн тайланд аудит хийх байгууллагыг сонгон шалгаруулах комисст цаашид Хяналтын зөвлөлийн гишүүдийг оролцуулахгүй байх, мөн Монголбанкны

санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх компанийн төлөөлөлтэй Хяналтын зөвлөлийн зүгээс уулзаж холбогдох асуудлаар санал бодлоо солилцож байх нь зүйтэй гэж үзсэн байна.

3. Хяналтын зөвлөлөөс Монголбанкны Ерөнхийлөгч хуулийн хүрээнд эрхээ хэрэгжүүлэх баталгааны хэрэгжилтийн байдлыг судалж уг асуудлыг хурлаар хэлэлцсэн байна. Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийн ТӨ-VA-д Монголбанкны Ерөнхийлөгчийн албан тушаалыг оруулсан нь Монголбанкны эрхэлж буй үйл ажиллагаа, хүрээ хийгээд түүнийг удирдаж байгаа Ерөнхийлөгчийн эрх зүйн байдлыг дутуу үнэлж байна гэж үзэв.

Монголбанкны Ерөнхийлөгчийн хэрэгжүүлэх бүрэн эрхийн баталгааны талаар Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд заасан заалтыг бүрэн хэрэгжүүлэх, Монголбанкны эрх зүйн тогтолцооны онцлог хийгээд түүний эрхэлж байгаа ажлын цар хүрээ, өвөрмөц байдлыг харгалзан төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаатай адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэл дэх Монголбанкны Ерөнхийлөгчийн албан тушаалыг зэрэглэлийг ахиулж, ТӨ-IVA зэрэглэлд хамааруулах саналыг УИХ-д оруулах нь зүйтэй гэж Хяналтын зөвлөлөөс шийдвэрлэжээ.

4. Монголбанкны Мэдээллийн технологийн газрын захирлын сонголыг хэлэлцээд Монголбанкны нягтлан бодох бүртгэлийн программ хангамжийг шинэчлэх ажлыг зохион байгуулж, шаардагдах хөрөнгийг шийдвэрлэх арга замыг судлах, Мэдээллийн технологийн газрын бүтэц, зохион байгуулалтыг дахин авч үзэж цахим мэдээллийн аюулгүй байдалд тавих хяналтыг тогтмолжуулж энэ чиглэлээр ажиллах ажилтны орон тоог бололцоотой хэмжээнд нэмэгдүүлэн ажлын байрны тодорхойлолт, гүйцэтгэх чиг үүргийг нарийвчлан тогтоож, мэргэшсэн сайн багийг бүрдүүлэх, ажилтны мэдлэг боловсролыг байнга дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллах талаар Монголбанкны удирдлагад зөвлөмж хүргүүлсэн байна.

Мэдээллийн системийн нууцлалыг хангах, аюулгүй байдлын хяналтыг байнгын болгох замаар аливаа болзошгүй халдлагыг илрүүлэх бололцоог богиносгох, хариу үйлдлийг цаг алдалгүй авах чадамжийг дээшлүүлэх, мэдээллийн системд гарч болох эрсдэлээс хамгаалах, богино хугацаанд хэвийн ажиллагаанд оруулахад шаардлагатай хүчин чадал бүхий сервер, тоног төхөөрөмжийн нөөцийг бүрдүүлж ажиллахыг зөвлөжээ.

5. Монголбанкны Хяналтын зөвлөл 2011 онд 5 удаа хуралдаж, өөрийн бүрэн эрхийн талаар Төв банкны тухай хууль тогтоомжид заасан асуудлыг хэлэлцэж, 41 заалт бүхий 13 тогтоол, 3 заалт бүхий 1 тэмдэглэл, нийт 42 заалттай шийдвэр гаргасан нь өмнөх онд гаргасан шийдвэртэй харьцуулахад нэмэгдсэн бөгөөд биелэлтийг тооцох 37 зөвлөмжөөс бүрэн биелсэн шийдвэр 16, дутуу биелэлттэй буюу хийгдэж байгаа 14, хугацаа болоогүй 2, биелээгүй 5 заалт бүхий зөвлөмж байгааг хурлаас тэмдэглэв.

Монголбанкны зүгээс Хяналтын зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд заалт бүрээр хяналтын карт нээж, биелэлтийн явцын талаар Захирлуудын зөвлөлийн шуурхай зөвлөгөөнөөр хэд хэдэн удаа хэлэлцэж, хариуцсан газрын захирлаар биелэлтийг хянуулсны эцэст нэгтгэн Хяналтын зөвлөлд ирүүлэх зэргээр ажилласан нь 2011 онд гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажил урьд онуудтай харьцуулахад ахицтай байна гэж Хяналтын зөвлөлөөс дүгнэв.

Хяналтын зөвлөлөөс зөвлөмж болгосон зарим шийдвэрийг хэрэгжүүлэхэд асуудлыг хариуцсан захирлын хариуцлагыг дээшлүүлэх, Хяналтын зөвлөлийн шийдвэрт ёс төдий хандаж, хэрэгжүүлэх талаар санаачлагагүй ажилласан хүмүүстэй хариуцлага тооцож байх талаар шийдвэрт тусгажээ.

Мөн энэ хурлаас мөнгөн тэмдэгт захиалж хийлгэх, гүйлгээнд гаргахтай холбогдсон асуудлыг хариуцсан газрыг Монголбанкны бүтцэд шинээр зохион байгуулах гэж байгаатай холбогдуулан мөнгөн тэмдэгт захиалж хэвлүүлэх гэрээг гадаадын компанитай байгуулахад Мөнгөний бодлого, судалгааны газрын захирал гарын үсэг зурж байгаа практикийг хэвээр мөрдөхөөр шийдвэрлэсэн заалтыг дахин хянан үзэж, эрх ашиг, сонирхолын зөрчил гарахгүй байх хяналтын тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээ авахыг Монголбанкны удирдлагад дахин зөвлөсөн байна.

МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ